



Улсын болон
орон нутгийн
төсвийн 59
байгууллага


Үүнээс:

АХМАДЫН
САНГИЙН ДАНС
НЭЭСЭН 50

АХМАДЫН
САНГИЙН ДАНС
НЭЭГЭЭГҮЙ 9

АХМАДЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

АХМАДЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



1.3 сая төгрөг

Байгууллага, салбартаа онцгой үр бүтээл гарган олон жил идэвх зүтгэлтэй ажилласан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох

188.1 сая төгрөг


Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл гардуулах

1.9 сая төгрөг

Нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг ахмад настанд түлш худалдан авахад зориулан мөнгөн дэмжлэг үзүүлэх

2.0 сая төгрөг

Хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ахмад настанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх



10.3 сая төгрөг

Эрүүл мэндийн шалтгаанаар удаан хугацаагаар өвчтэй байгаа ахмад настанд эмчилгээний зардалд зориулж мөнгөн тусламж үзүүлэх

1.4 сая төгрөг

Ахмад настан өөрөө эсхүл, түүний нөхөр (эхнэр) нь нас барсан тохиолдолд мөнгөн тусламж олгох

15.8 сая төгрөг

Ахмадуудын дунд идэвхтэй насжилтыг дэмжих амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

3.9 сая төгрөг

Хуульд заасан хүрээнд ахмад настанд чиглэсэн бусад хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх



АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

9 төрийн байгууллага

Ахмадын сангийн
харилцах данс
нээлгээгүй

3 төрийн байгууллага

Ахмад настанд хууль, журмаар
үзүүлэх арга хэмжээний зардлыг 3
байгууллага тухайн жилийн урсгал
үйл ажиллагааны зардлаас 1.5 сая
төгрөгийг зарцуулсан

4 төрийн байгууллага

Ахмад настанд хууль журмаар
үзүүлэх арга хэмжээнд огт зардал
гаргаагүй, хуулийн хэрэгжилтийг
хангаж ажиллаагүй

2 төрийн байгууллага

Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулахдаа
анхан шатны баримтын бүрдэлт дутуу, тайлан
бүртгэл байхгүй, нотлох баримтуудыг бүрэн
хүлээн авч хүсэлтийг шийдвэрлээгүйгээс ахмад
настнуудад олгож буй тусламж дэмжлэгийн
хэмжээ харилцан адилгүй, ялгаатай олгосон

2 төрийн байгууллага

Ахмадын сангаас хөрөнгө зарцуулах шийдвэр
гаргахдаа Ахмад настны тухай хууль болон
Ахмадын сан байгуулан ажиллах журмын
холбогдох заалтыг үндэслэл болгоогүйгээс
журмын ямар заалтаар ямар арга хэмжээнд
зарцуулагдаж байгаа нь тодорхойгүй

Аймгийн Ахмадын хороо

Ахмадын сан байгуулан ажиллуулах
журмын хэрэгжилтэд хөндлөнгийн
хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий
аймгийн Ахмадын хорооноос сангийн
зарцуулалтад тавих хяналтыг үр
дүнтэй хэрэгжүүлээгүй

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Ахмадын сангаас ахмадуудад хүндэтгэл үзүүлж
буй тэтгэмж тусламжийн мөнгөн дүнгээс зарим
төрийн байгууллагууд ХХОАТ суутган
тооцсоныг аймаг, сумдын Төрийн сан төлбөр
тооцоог хянаж баталгаажуулахдаа харилцан
адилгүй хянаж гүйлгээг баталгаажуулсан

Аймгийн Цагдаагийн хэлтэс

Ахмадын зөвлөлийн ажлын төлөвлөгөө, тайлан
батлуулаагүй, хууль журмын дагуу хэрэгжүүлсэн
ажлын тайлан байхгүй, байгууллагын удирдлага
болон санхүүгийн ажилтны зүгээс дотоод
хяналтыг хэрэгжүүлээгүй, ахмадын сангийн
орлого төвлөрүүлэлт, зарцуулалтын талаар ил,
тод мэдээлээгүй



АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ

Аймгийн Ахмадын хороонд:

01

Төрийн байгууллагуудын ахмадын сангийн зарцуулалтад тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Төрийн байгууллагуудад:

02

1. Ахмадын сангийн харилцах данс нээх, журмын дагуу орлого төвлөрүүлэх, тус сангийн хөрөнгийг ахмад настанд үзүүлэх арга хэмжээнд зарцуулах
2. Ахмад настанд хууль, журмаар үзүүлэх арга хэмжээний зардлыг байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас зарцуулахгүй
3. Ахмадын сангийн хөрөнгийг зарцуулахад анхан шатны баримтын бүрдлийг хангах, нотлох баримтуудыг бүрэн хүлээн авч шийдвэрлэх
4. Ахмад настнуудад олгож буй тусламж дэмжлэгийн хэмжээг Ахмад настны тухай хуульд заасан үл ялгаварлах, эрх тэгш байх зарчмыг баримталж олгох

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст:

04

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө", 22.1.1-д "хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэж заасны дагуу хяналтыг хэрэгжүүлэх

Аймгийн Цагдаагийн хэлтэст:

03

1. Ахмадын зөвлөл нь тухайн жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийн тайланг гаргаж тайлагнах, байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх
2. Ахмадын зөвлөл нь ахмадын сангийн орлого төвлөрүүлэлт, зарцуулалтын талаар ил тод мэдээлэх, байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтны зүгээс Ахмадын зөвлөлтэй хамтран ажиллах ажлын уялдаа холбоог сайжруулах



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

1

Ахмад настны тухай хуульд нийгмийн даатгалын сангаас өндөр насны, эсхүл цэргийн алба хаагчийн тэтгэвэр авч байгаа иргэд хуулийн үйлчлэлд хамаарах эсэхийг тодорхой болгож, нэмэлт өөрчлөлт оруулах

3

Улсын хэмжээнд ахмад настнуудын бүртгэл, мэдээлэл, шилжилт хөдөлгөөн, байгууллагын харьяалал гэх мэт мэдээллийг багтаасан нэгдсэн цахим системтэй болгох, төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх

5

Ахмад настны тухай хуулийн 14.6-д зааснаар ААНБ нь харьяалалгүй ахмадыг бүртгэж авах эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа тул харьяалалгүй ахмадыг төрийн байгууллагад хуваарилах тоо, квотыг тогтоосон эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох

2

Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-д ахмад настны давхар харьяаллын асуудлыг тодорхой болгож, өөрчлөлт оруулах

4

Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-д мөнгөн дэмжлэг, тусламжийн хэмжээг тодорхойлох, нэмэлт өөрчлөлт оруулах